



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/667

Ховд

Газар өмчлүүлэх эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтуудыг үндэслэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2006 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 70 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Бугат багийн 3-16 тоот, 500,0 м² хэмжээтэй, 1250000 төгрөгийн үнэ бүхий газрын иргэн Х.Алтанцэцэг, Батцэцэг нарт, аймгийн Засаг даргын 2007 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 30 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Баатархайрхан багийн 11-3 тоот, 925м² хэмжээтэй, 3990000 үнэ бүхий газрыг иргэн Ш.Галсаннамжилд тус тус үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Дээрх нэр бүхий иргэдэд шилжүүлсэн газарт хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/, Улсын бүртгэлийн хэлтсийн хэлтсийн дарга /Хоролсүрэн/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг дарын 2006 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 70 дугаар захирамжийн 127-130 дахь заалтын Ц.Булганбат, Ц.Бат-Эрдэнэ, Ц.Батнасан, Ц.Батбаяр нарт холбогдох хэсгийг, аймгийн Засаг даргын 2007 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 30 дугаар захирамжийн 5 дахь заалтын Д.Оюундэлгэр, Г.Баянжаргал, Г.Уламбаяр, Г.Намбардулам, Г.Бадамхорол, Г.Отгонбаяр нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02-2995

Аймгийн Засаг даргын 2020 оны
11 дүгээр сарын 05-ны өдрийн А/667 дугаар
захирамжийн хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

Овог нэр	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар өмчилж авсан захирамжийн огноо	Дугаар	Хавсралтанд орсон дугаар
Ц.Булганбат Ц.Бат-эрдэнэ Ц.Батнасан Ц.Батбаяр	Бугат баг 3-16 тоот	500,0	2006-04-17	70	127-130
Д.Оюундэлгэр Г.Баянжаргал Г.Уламбаяр Г.Намбардулам Г.Бадамхорол Г.Отгонбаяр	Баатархайрхан баг 11-3 тоот	925,0	2007-02-07	30	5